



ХасБанкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хорооны дүрэм

1-р зүйл. Хорооны зорилго

- 1.1 ХасБанкны /цаашид “Банк” гэх/ шийдвэр гаргах дээд эрх нь Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-д байх ба Төлөөлөн удирдах зөвлөл нь хүүгийн хэмжээ, хөрвөх чадвар, гадаад валют, улс төр, үйл ажиллагаа, нэр хүндийн эрсдэлийг удирдах, зохицуулах бодлого журам, бизнес стратегийг батлах, эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд Банкны зээлийн эрсдэлийг тодорхойлох, удирдах үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх, Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ, энэхүү дүрмээр болон Банкны бусад эрсдэлийн удирдлагын бодлого, журмаар зохицуулагдах эрсдэлийн бодлого, журмууд, цочролын сорилын үр дүнг батлах гэх мэт шийдвэр гаргах эрхээ бүхэлд нь ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороо /Цаашид “ЭУХ” гэх/-нд шилжүүлж болно.
- 1.2 Хорооны дүрмээр хорооны зорилт, зорилго, үүрэг хариуцлагыг тодорхойлох бөгөөд энэхүү дүрмийг ТУЗ-ийн тогтоолоор батална. ЭУХ нь Банкан дахь эрсдэлийг тодорхойлох, удирдах үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.
- 1.3 ЭУХ нь Банкны гүйцэтгэх удирдлага нь хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавина.
- 1.4 ЭУХ нь энэхүү дүрэмд заасан үүрэг хариуцлага, эрхийг эдлэх хэдий ч эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх, түүнчлэн Банк нь холбогдох хууль, тогтоомж, Банкны ёс зүйн дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах, үнэлэх үүрэг хүлээхгүй.
- 1.5 Хорооны бусад ерөнхий дүрэм, журамтай холбоотой асуудал нь ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмаар зохицуулагдана.

2-р зүйл. Хорооны үүрэг, хариуцлага

Хороо нь хянах үүргийхээ хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

- 2.1 Зээл, хүүгийн хэмжээ, хөрвөх чадвар, гадаад валют, үйл ажиллагаа, комплаенс, нэр хүнд болон хууль, эрх зүйн эрсдэлийг удирдан зохицуулах Банкны эрсдэлийн удирдлагын бодлогыг хянах, үнэлэх; Эрсдэлийн удирдлагын бодлогуудыг хувьсан өөрлөгдөж буй гадаад орчин, стратеги, Банканд шинээр бий болж болзошгүй эрсдэлд нийцүүлэн жил бүр хянаж буй эсэхэд хяналт тавих;
- 2.2 Банкны эрсдэлийн хэмжээ нь ТУЗ-өөс баталсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд байгаа эсэхийг үнэлэх, хянах;
- 2.3 Банкны бизнесийн нэгжүүдэд тулгарч буй материаллаг эрсдэлийг бууруулахаар удирдлагын хэрэгжүүлж буй төлөвлөгөө нь зохистой эсэхэд хяналт тавих, үнэлэх;
- 2.4 Эрсдэлийн удирдлагын чиг үүргийн хараат бус бөгөөд үр дүнтэй байдлыг үнэлэх, хянах; Банкны бизнесийн зохистой бүтцийг бий болгох, болзошгүй эрсдэлийг үр дүнтэй удирдах, эрсдэлийн хяналт, хязгаар үзүүлэлтийг тогтоосон Банкны зохистой бодлого, журмыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, хянахад шаардагдах нөөцийн хүрэлцээтэй байдлыг хангаж ажиллах;
- 2.5 Банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-д өгсөн зөвлөмжийг үнэлэх, хянах;
- 2.6 Зээлийг эрсдэлийг удирдах ерөнхий журам болон Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд тодорхойлсон Эрсдэлийн хязгаар үзүүлэлтүүд, гүйцэтгэх удирдлагад шилжүүлсэн эрх хэмжээ болон ТУЗ-ийн хянах чиг үүрэг бүхий хороодыг үнэлэх, хянах;
- 2.7 Гүйцэтгэх удирдлагад FMS'-ээс олгосон эрхийн хэмжээнээс хэтэрсэн хөрөнгө оруулалт

- болон арилжааны нөөц бүрдүүлэх саналыг хянах;
- 2.8 Банкны эрсдэлд тавих хяналтыг үнэлэх зорилгоор Банкны эрсдэлийг улирал бүр хянах;
 - 2.9 Голлох эрсдэлийн хүчин зүйлс болон таамаглалыг хамруулсан эдийн засгийн капиталын түвшинг үнэлэх, хянах;
 - 2.10 Мэдээллийн технологийн эрсдэлийн хяналтын үр дүнтэй байдлыг үнэлэх, хянах;
 - 2.11 Хууль, эрх зүйн нийцэл, бодит болон мэдээллийн аюулгүй байдал, ашиглан, даатгалын гэх мэт бусад төрлийн эрсдэлд зохих ёсоор хяналт тавих;
 - 2.12 Банкны бодлогод заасан эрхийн хэмжээнээс хэтэрсэн удирдлагатай холбоотой санал болон хэлцлийг үнэлэх, хянах;
 - 2.13 Эрсдэлийн төлөв болон эрсдэлийн удирдлагад нөлөө үзүүлж болзошгүй гэж дотоод аудитаас дэвшүүлсэн асуудлыг үнэлэх, хянах;
 - 2.14 Банкны гүйцэтгэх удирдлагад олгосон зээл шийдвэрлэх болон зээлийг сангаас хаах эрхийн хэмжээнд хяналт тавих, аливаа өөрчлөлтийг ТУЗ-д танилцуулах, батлуулах;
 - 2.15 Зээл, түүнтэй адилтгах бүх активыг хамгийн зохистой эрсдэлийн үнэлгээний системийн дагуу ангилж буй эсэхэд хяналт тавих болон зээлийг үнэн зөв ангилсан эсэхийг 6 сар тутамд баталгаажуулах;
 - 2.16 Зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журамд зааснаас өөр нөхцөлтэй зээлийг цаг тухайд нь тодорхойлон, тайлагнаж, баталж буй эсэхийг зээлийн багцын тайлангаар хянах;
 - 2.17 ХасБанкны ажилтнуудын орон сууцны зээл болон ажилтны ХасБанк, ХасЛизинг дэх зээл, санхүүгийн түрээсийн нийт дүн нь 300 сая төгрөгөөс дээш дүнтэй санхүүгийн түрээсийн саналыг хянах, батлах;
 - 2.18 Банкны холбогдох этгээдийн зээл, түүнтэй адилтгах актив, ӨБҮХХ¹-ийн хэлцлийн хүсэлтийг хянах, батлах, сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-д танилцуулж батлуулах;
“Сонирхлын зөрчилтэй хэлцэл” гэдгийг Компанийн тухай хуулийн 89.1 дэх заалтын дагуу тодорхойлох бөгөөд тус заалтад “Компанийн энгийн хувьцааны 20% буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч” гэснийг “Компанийн энгийн хувьцааны 5% буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч” гэж ойлгоно.
 - 2.19 Нэг харилцагч, түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдийн 25 тэрбум төгрөгөөс дээш дүн бүхий зээлийг хянах, шийдвэрлэх;
 - 2.20 Зээлийг сангаас хаах шийдвэрийг гаргах, хянах;
 - 2.21 Эрсдэлийн сангийн хэмжээний зохистой байдлыг баталгаажуулах, хянах;
 - 2.22 Хэвийн болон чанаргүй зээлийн нийт багцын тайланг хүлээн авч үнэ цэнийн бууралттай зээлийг цаг тухайд тэмдэгдэж тохирох нягтлан бодох бүртгэлийн бүртгэлд бүртгэж байгаа эсэхийг хянан баталгаажуулах;
 - 2.23 1-ээс дээш хоногтой эрсдэлтэй зээлийн багц, хүү хуримтлахыг зогсоосон зээл, ӨБҮХХ-д бүртгэсэн хөрөнгө болон Банкны анхаарал татсан зээлийг жагсаалтад орсон зээлийг хянах;
 - 2.24 Банкны удирдлага нь хэлцлийн хүсэлт, судалгаа, шийдвэр гаргалт, олголт болон бичиг баримтжуулалтын хяналтын үйл ажиллагааг зохистойгоор ялган тусгасан журмыг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих. Банкны гүйцэтгэх удирдлагад эрхээ шилжүүлсэн нь ТУЗ болон түүний дэргэхэд ЭУХ-ны Банкны зээлийн чиг үүргийг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэх үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

¹ ӨБҮХХ=Өмчлөх Бусад Үл Хөдлөх Хөрөнгө гэж зээлийн төлбөрт тооцон бусдаас авч Банкны эзэмшил, өмчлөлд шилжүүлсэн хөрөнгийг хэлнэ.